



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 8/09

Даланзадгад

“Коронавируст халдварт (Covid-19)-ын болзошгүй өндөржүүлсэн бэлэн байдлын эмнэлгийн тусlamж үйлчилгээг зохицуулах тухай”

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 33.1.5, 34 дугаар зүйлийн 34.2.4 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн шинэ коронавирусийн халдвартын эрсдэл, өртөлтийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Коронавируст халдвартын (Covid-19) өндөржүүлсэн бэлэн байдлын үед эмнэлгийн тусlamж үйлчилгээг зохицуулах түр журмыг нэгдүгээр, шинэ коронавирусийн болзошгүй өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн тусгаарлах өрөөнд тавигдах шаардлагыг хоёрдугаар, зөвлөх эмчийн бүрэлдэхүүн, чиг үүргийг гуравдугаар, коронавирусийн халдвартын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх асуумжийн зураглалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Коронавирус халдвартын (Covid-19)-ын болзошгүй өндөржүүлсэн бэлэн байдлын үед эмнэлгийн тусlamж үйлчилгээг зохицуулах түр журмыг шуурхай хэрэгжүүлэн ажиллахыг эмнэлгүүдийн захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Эмнэл зүйн багт ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн цалин, урамшууллыг хууль, тогтоомжийн хүрээнд олгохыг байгууллагуудын захирал, дарга эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.
4. Коронавируст халдвараас (Covid-19) урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ариутгал, халдвартгүйтгэлийн зохион байгуулах ажлыг мэргэжлийн арга зүйгээр чангаж ажиллахыг Зооноз өвчин судлалын төвийн дарга, хурц халдварт болон олон улсын хол хориот өвчний ажлын хэсгийн ахлагч /Д.Алтанчимэг/-д үүрэг болгосугай.

5. Коронавирусийн болзошгүй халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисын нөөцийг төлөвлөн, тогтвортой хангамжийг бүрдүүлж ажиллахыг эм ханган нийлүүлэх байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Түр журмыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр ханган ажиллаж, хэрэгжилтийн түвшинд үнэлгээ хийж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга /Ж.Огонбайгал/-д нарт даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж өгч ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга /Б.Мидэрсүрэн/-д даалгасугай.



Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн  
A/09 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (Covid-19)-ЫН БОЛЗОШГҮЙ ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН  
БАЙДЛЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд доорхи баримт бичгүүдийг бүрэн уншиж, судална. Үүнд:
  - Монгол Улсын Гамшигаас хамгаалах тухай хууль; /2017 оны шинэчилсэн найруулга/
  - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
  - Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаал “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”
  - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”
  - Эрүүл мэндийн сайдын 2020 оны 19 дүгээр албан даалгавар “Шинэ коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай”
  - Улсын онцгой комиссын 2020 оны хурлын тэмдэглэлүүд
  - Коронавируст халдвар (COVID-2019)-ын үеийн эмнэл зүйн түр заавар. 2020 оны 02 дүгээр сарын 12-ны өдөр
  - Шинэ коронавирус (2019-n CoV)-ийн халдвартын сэжигтэй амьсгалын цочмог хүнд халдвар (АЦХХ)-ын эмнэл зүйн менежмент, Завсрын удирдамж, 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр ДЭМБ, орчуулсан Ш.Энхтөр, АУ-ны доктор, клиникийн профессор
  - ЭМС-ын 2020 оны A/93 дугаар тушаал “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”
  - ЭМС-ын 2018 оны A/438 дугаар тушаал “Томуугийн цар тархалтын бэлэн байдал, хариу арга хэмжээ”
  - ЭМС-ын 2015 оны A/242 дугаар тушаал “Хүний коронавируст халдвартын тандалт, оношилгоо, эмчилгээ, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар”
  - ЭМС-ын 2020 оны A/32 дугаар тушаал “Эмнэл зүйн зөвлөх багийн ажиллах журам, чиглэл батлах тухай”
  - Өмнөговь аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавар “Шинэ коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх тухай”
  - Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын A/06 дугаар тушаал “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг батлах тухай”
  - ЭМС-ын 2017 оны 505 дугаар тушаал “Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, утгах заавар”
  - ЭМС-ын 2019 оны 536 дугаар тушаал “Дүрэм жагсаалт батлах тухай”
  - ЭМС-ын 2019 оны 537 дугаар тушаал “Заавар батлах тухай”
  - Эрүүл мэндийн сайдын 2017 оны A/43 дугаар тушаал “Ажиллах журам, бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь батлах тухай”
  - Аймгийн засаг даргын 2020 оны A/88 дугаар захирамж “Шинэ Коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх чиглэл өгөх тухай”

- Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамж “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”
  - Аймгийн Засаг даргын 2020 оны А/146 дугаар захирамж “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”
2. Эрүүл мэндийн байгууллагууд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой Гамшгийн үеийн бэлэн байдлын мэргэжлийн ангийн төлөвлөгөөндөө тодотгол хийж, ажил хариуцсан мэргэжилтнүүдэд үүргийг нь танилцуулан, гарын үсгээр баталгаажуулна.
  3. БОЭТ-ийн Зөвлөх эмч нарын багийг хуралдуулж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед мэргэжлийн ангийг эмнэл зүйн заавар зөвлөмжөөр эмнэлгүүдийг хангаж ажиллана.
  4. Эмнэл зүйн баг нь эмнэлгүүдэд долоо хоногийн Мягмар, Пүрэв гарагуудад 10-12 цагийн хооронд эмнэл зүйн цахим сургалт тогтмол зохион байгуулна.
  5. Эмнэлэг бүр шинэ коронавирусийн сэжигтэй тохиолдолд үзүүлэх тусlamж үйлчилгээ, үүрэг, оролцооны зураглалыг гарган ажилчдыг үүрэгжүүлэх, ажлын байрны сургалт зохион байгуулж, ур чадварын үнэлгээг үнэлж ажиллана.
  6. Шинэ коронавирусийн болзошгүй өндөржүүлсэн бэлэн байдлын үед эмнэлгийн тусlamж үйлчилгээг хүргэхэд томилогдсон мэргэжлийн багийн сэтгэл зүйн бэлтгэл ажлыг эмнэлэг бүр идэвхтэй зохион байгуулна. Дадлага сургалтыг 2-3 удаа хийж тухай бүр Эрүүл мэндийн албаны түр штабт тайлагнана.
  7. Эрүүл мэндийн газар нь шинэ коронавирусийн болзошгүй халдвартын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисын нөөцийг тогтвортой байлгах зорилгоор эм ханганд нийлүүлэх байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулан ажиллана.
  8. Шинэ коронавирусийн сэжигтэй тохиолдолд Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс дуудлага очих маршрутыг өрхийн эрүүл мэндийн төвүүд гаргаж, БОЭТ-ийн дуудлагын жолооч нар зураглалын дагуу хүрч очиж дадлагажих ажлыг зохион байгуулна.
  9. Эмнэлэг бүр түргэн тусlamжийн халуурсан өгүүлэмжтэй дуудлага бүрт Шинэ коронавирусийн тархвар судлалын асуумж авч, халдвартыг эрт илрүүлэх горимоор ажиллана.
  10. Эмнэлгүүд амбулаторийн үйлчилгээг нэг урсгалд шилжүүлэн, орох хаалган дээр эрүүл мэндийн мэргэжлийн хүн ажиллуулна. Тус мэргэжилтэн нь орж ирсэн бүх хүний халууныг хэмжин, амны хаалтгүй үйлчлүүлэгчийг эмнэлгийн орчинд нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авч, халуунтай үйлчлүүлэгчээс Шинэ коронавирусийн тархвар судлалын асуумж авч, дараагийн арга хэмжээг шуурхай авах тогтолцоог бүрдүүлнэ. Орох хэсэгт автоматаар ажилладаг гар халдвартгүйтгэх уусмал байрлуулна. Энэ хэсэгт ажиллах мэргэжилтэн нь N95 амны хаалт, бээлий өмссөн байна. Тархвар судлалын асуумж хөтлөх ур чадварыг эзэмшсэн байна.
  11. Хэвтэн эмчлүүлэх хэсэгт эргэлтийг хязгаарлана, шаардлагагүй хэвтэлтийг цөөлнө.
  12. Эмнэлгүүдийн хяналтын камерыг өндөржүүлсэн бэлэн байдлын халдварт хамгааллын дэглэмийг чангатгахад ашиглаж, орчин болон инженерийн хяналтыг сайжруулна.
  13. Эмнэлгийн үйлчлэгч, асрагч нарт “Шинэ коронавирусийн халдвартын үеийн хог хаягдал цуглуулах, устгах, ангилах, цэвэрлэгээ, халдвартгүйтгэл” сэдвээр сургалт зохион байгуулж, ур чадвар эзэмшүүлнэ.
  14. Эмнэлгийн нийт ажилчид гар угаалт, гар халдвартгүйтгэлээр өөрийн үнэлгээ хийж, стандарт зөрчил гаргасан тохиолдолд бие дааж эзэмшинэ.
  15. Тусгаарлах өрөөг дараах шаардлагад нийцүүлэн бүрдүүлнэ.


## Тусгаарлах өрөөнд тавигдах шаардлага:

- Гадна талд сээрмжлүүлэг, анхааруулах тэмдэг тавьсан байна.
- Халдвартын хяналтын бүс зөв зохион байгуулагдсан байна.
- Хамгаалах хувцас хэрэглэл /комбинезон, халад малгай, бээлий, шүүлтүүртэй амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, гутлын гадуурх улавч/ таглаатай саванд бэлтгэсэн байна.
- Хамгаалах хэрэгсэлд хэрэглэх халдвартгүйтгэлийн уусмал, хэрэглэх сав суулга, зүү нэвтрэхээс сэргийлсэн хамгаалалттай бээлий бэлэн байна;
- Хамгаалах хувцас хэрэглэл өмсөх тайлах дарааллын зааварчилгаа хананд хадсан байна.
- Хамгаалах өмсгөл өмсөх, тайлахыг хянах том толь, зааварчилгааг уншсан бичлэг, спикер.

### Дотор талд

- Хaalга бүрэн хаагддаг, вакумжуулсан, эмнэлгийн бусад хэсэгт агаар тархахааргүй зохион байгуулагдсан байна.
- Агааржуулалт сайтай нэг хүний өрөөнд тусгаарлана. Ор хоорондын зай 1 метрээс багагүй байна.
- Өрөөний хэм 18-аас дээш байна. Хэмжих хэрэгсэл байрлуулна.
- Өвчтөний баримтлах зарчим, эмнэлгийн мэргэжилтний өвчтөнтэй харьцах халдварт хамгааллын дэглэмийн санамжийг тусгайлан бэлтгэж хананд байрлуулсан байна. Гадагшаа холбогдох найдвартай харилцаа холбооны хэрэгсэл, суурин утас, гаднаас зааварчилгаа авах микрофон, камер байрлуулсан, мэдээлэл цуглуулах анхан шатны маягт бүртгэл бүрэн, мэдээллийг бүрэн авч, дамжуулах боломжийг бурдуулсан байна.
- Өвчтөнийг тээвэрлэх тохиолдолд урьдчилж мэдэгдэх маршрут, болзошгүй халдвартын үеийн тусlamж үзүүлэх үед холбогдох утасны жагсаалтыг байрлуулсан байна.
- Багаж, хэрэгслийг аль болох нэг удаагийн эсвэл тухайн хүнд хэрэглэх байдлаар шийдсэн байна. /Чагнуур, даралтын аппарат, халууны шил, пульсоксиметр/
- Зөөврийн рентген болон бусад амилуулах тусlamж, сэхээн амьдроуулах тоног төхөөрөмжүүдийг ашиглах бэлэн байдлыг хангасан байна.
- Гар угаах, бие засах орчныг бурдуулсан байна.
- Бие засах болон бусад ялгадсыг халдвартын сэргийлэлт алдагдахааргүй зохицуулалт хийгдсэн байна.
- Цагаан хэрэглэл, өвчтөний дулаан алдалтаас хамгаалах хэрэглэл бэлтгэсэн байна.
- Спиртэд суурилсан гар халдвартгүйтгэх уусмалыг хүрэлцээтэй байлгана. (Автомат горимтой)
- Хэрэглэх багажийн цэвэрлэгээ, халдвартгүйтгэл, ариутгалын зохицуулалт хийгдсэн байна.
- “Биологийн аюултай” хаягтай хогийн уутыг хөлөөр онгойлгодог хогийн саван дотор байрлуулна.
- Үйлчлүүлэгч хүрэлцдэг эмнэлгийн эд зүйл, тоног төхөөрөмжийн гадаргууг тогтмол цэвэрлэж, халдвартгүйжүүлэх боломжийг бурдуулнэ.
- Халдвартын сэжигтэй үйлчлүүлэгчтэй хавьтал болох эргэлтийн хүмүүс, гэр бүлийн гишүүд, эмнэлгийн ажилтны тоог хязгаарлах дурмийг тодорхой болгож баталгаажуулан, байрлуулсан байна.
- Ажилбарын дараа орчныг цэвэрлэх, халдвартгүйжүүлэх нөхцөл бурдуулнэ.

16. Ажилтан бүрд 5 ээлжийн халдварт хамгааллын өмсгөл, хэрэглэлийг таарах хэмжээтэйг сонгон, багц болгон бүрдүүлж, өмсөх дарааллаар нь уутанд хийж, ажилтны нэрийг нь тавьж хаягжуулан хадгална. Үүнд:
- Хамгаалах өмсгөлийн дотуур өмсөх эмнэлгийн хувцасны ханцуй нь бугуй давсан, шуу нь шагай давсан байна.
  - Эмнэлгийн гутал нь битүү байна.
  - Эмнэлгийн нэг удаагийн малгай өмсөж үсийг бүхэлд нь далдалсан байна. Үсийг урьдчилан сүлжиж, шууж боосон байна.
  - Ээмэг бөгж, гоёл зүүлтийг ажлын байран дээр хэрэглэхгүй.
  - Нэг удаагийн шүүлтүүртэй амны хаалт хэрэглэх (N95) Анхаарах зүйл: FFP2, FFP3 зэрэг шүүлтүүрийн тэмдэглэгээтэй тоосонцор шүүх амны хаалтыг хэрэглэхгүй, ярих, амьсгалах үед ам руу татагдаж хонхойдоггүй байна.
  - Нүдний шил нүүрнээс хөндийрөхгүй, бүрэн шүргэлцсэн, нүхгүй, цантахаас сэргийлэх аргыг туршиж хэрэгжүүлсэн, цантахгүй байна.
  - Нүүрний хамгаалалтыг заавал хэрэглэнэ.
  - Шингэн нэвтрүүлдэггүй 1 удаагийн комбинезон байх бөгөөд малгай нь нүдний шил, амны хаалтыг давсан байна. Ханцуй, шуумаг нь эмнэлгийн хувцаснаас давсан хэмжээтэй байна. Эмнэлгийн ажилтны арьс ил гарахгүй байна.
  - Гарын хэмжээнд тохирсон, шууны бугуй талаасаа 2/3 хүртэлх урттай, мэс заслын ариун бээлий 3 ширхэг байна.
  - Усны гутал хөлийн шилбэний ½ хүрэх өндөртэй, бүрэн бүтэн байна.
  - Өвчтөнтэй шууд харьцах үед нэг удаагийн арагш харсан энгэртэй халад өмсөж болно.
  - Хувцас өмсөхөд хяналтын болон туслах ажилтана;
17. БОЭТөв халдвартын тасагт 5 тусгаарлах өрөө, сум өрхийн эмнэлгүүд 1-3 тусгаарлах өрөөг тесвийн хүрээнд 100% бүрдүүлэн, үнэлгээний хуудсыг ажлын хэсгийн гарын үсэг, байгууллагын тамгаар баталгаажуулан, 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтэст мэдээлж, нөөцийг өндөржүүлсэн бэлэн байдалд байлгана.
18. Шаардлагатай тохиолдолд болон бэлэн байдлын горим өөрчлөгдөхөд ор нэмж дэлгэх зохион байгуулалтыг төлөвлөсөн байна.
19. Халдвартын сэжигтэй голомт руу аль болох цөөн хүн оруулах, удирдах зохион байгуулах эмч 8 ажилтныг оруулахаас зайлс хийнэ.
20. Эрүүл мэндийн газар нь шинэ коронавирусийн болзошгүй тохиолдолд олон хүнийг түр хугацаагаар тусгаарлах байруудыг бусад байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулан бэлтгэнэ.
21. Шинэ коронавирусийн болзошгүй өндөржүүлсэн бэлэн байдлын үед удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлээгүй албан тушаалтан, эмнэлгийн тусlamж үйлчилгээг хүргэхэд томилогдсон ажилтан хүндэтгэн үзэх бус шалтгаанаар татгалзсан тохиолдолд зохих хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

  
 Эрүүл мэндийн газрын даргын  
 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн  
 А/09 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН БОЛЗОШГҮЙ ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН  
 ҮЕД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД БОЛОН ТУСГААРЛАХ  
 ӨРӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

№	Эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, тун хэмжээ	Эмийн хэлбэр	Хэмжих нэгж, тун	Байлгавал зохих доод хэмжээ			
				СЭМТ	СДЭ	ӨЭМТ	БОЭТ

**Нэг. Хамгаалах хувцас хэрэглэл**

1	Нэг удаагийн Mask		ш	200	200	300	500
2	Амны хаалт /N95/		ш	100	100	100	200
3	Нүүрний хаалттай малгай		ш	10	20	10	30
4	Нэг удаагийн халад		ш	20	20	20	50
5	Малгайтай комбинзон /T45/		ш	50	100	50	200
6	Нүдний шил /зориулалтын/		ш	10	20	10	50
7	Ус нэвтэрдэггүй хормогч		ш	5	10	5	30
8	Гутлын угглавч өндөр түрийтэй		ш	20	40	30	50
9	Малгай 1 удаагийн		ш	200	400	300	500
10	Цогцос хадгалах уут		ш	3	5		30
11	Бээлий /1 удаагийн/	№ M	хайрцаг	2	3	2	10
12	Ариун бээлий	№ 7.0, №7.5	хайрцаг	1	2	1	10
13	Усны гутал		хос	6	10	6	20

**Хоёр. Эмийн нөөц жагсаалт**

**2.1. Вирусийн эсрэг эм**

1	Ацикловир 200мг		шахмал	20	20	2	100
2	Оセルтамишивир 75 мг		шахмал	100	150	2	300

**2.2. Антибиотик**

4	Ампициллин 1 сая ЕД	тарилгын нунтаг	фл	10	20	10	200
5	Цефтриаксон 1гр	тарилгын нунтаг	фл	10	20	10	200
6	Цефазолин 1гр	тарилгын нунтаг	фл	20	50	10	200
7	Цефатаксим 1 гр	тарилгын нунтаг	фл	20	50		300
8	Хлорамфеникол 500мг	капсул	шахмал	20	30		100
9	Эритромицин 500мг	капсул	шахмал	30	50		200
10	Доксациклин 100мг	шахмал	шахмал	30	50		200
11	Ципрофлоксацин 100мг-10мл	тарилгын уусмал	амп	10	20		50
12	Гентамицин 80мг-2мл	тарилгын уусмал	амп	100	150		300

13	Глюкоза 5%-400мл	судсаар сэлбэх шингэн	фл	5	10			20
14	Глюкоза 40%-10мл	тарилгын уусмал	амп	10	20			50
15	Натрийнхлорид 0.9%-500мл	судсаар сэлбэх шингэн	фл	20	40	5		100
16	Натрийнхлорид 0.9%-100мл	судсаар сэлбэх шингэн	фл	30	50	5		200
17	Рингер 500мл	судсаар сэлбэх шингэн	фл	20	40			200
18	Калихлорид 7.5%-100мл	тарилгын уусмал	фл	5	5			20
19	Реополиглюкин 500мл	судсаар сэлбэх шингэн	фл	3	5			20
20	Декстран 70 400мл	судсаар сэлбэх шингэн	фл	3	5			20

#### 2.4. Цус тогтоох

21	Гепарин 1мл	тарилгын уусмал	амп	10	10			30
22	Викасол 1%-1.0	тарилгын уусмал	амп	30	50			300
	Этамзилат 250мг-2мл	тарилгын уусмал	амп	20	50			300
23	Аминокапроныхүчил 5%-100.0	тарилгын уусмал	фл	15	20			40
<b>2.5. Харшлын эсрэг гормоны бэлдмэл</b>								
24	Преднизолон 30мг/мл-1 мл	тарилгын уусмал	амп	5	10			30
25	Дексаметазон 4мг/мл-1мл	тарилгын уусмал	амп	20	40			200

#### 2.6. Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих

26	Допамин 40мг/мл - 5мл	тарилгын уусмал	амп	1	2	2		20
27	Адреналин 1мг/мл-1мл	тарилгын уусмал	амп	5	10	5		20
28	Атропин 1мг/мл - 1мл	тарилгын уусмал	амп	10	30			50
29	Кордиамин 250мг/мл/1мл	тарилгын уусмал	амп	10	30			100

#### Өвчин намдаах, булчин сулруулах

	Диклофенак натри 75мг/3мл	тарилгын уусмал	амп	20	50	5		300
	Анальгин 50%-2.0	тарилгын уусмал	амп	100	200	10		500
30	Но-шпа 40мг/мл-2мл	тарилгын уусмал	амп	30	50	5		200

31	Дифенгидрамин 1%-1мл	тарилгын уусмал	амп	100	200		500
<b>Хаван хөөх</b>							
32	Маннитол 10%-500.0	судсаар сэлбэх шингэн	фл	10	20		100
33	Фуросемид 1%-2мл	тарилгын уусмал	амп	20	50		100
<b>Бөөлжилтийн эсрэг</b>							
34	Метоклопрамид 5мг/мл-2мл	тарилгын уусмал	амп	10	20	5	100
<b>Сэтгэцэд нөлөөт</b>							
35	Тиопентал 1гр	тарилгын нунтаг	фл		3		10
36	Диазепам 10мг/мл-2мл	тарилгын уусмал	амп	5	20		50
37	Дроперидол 2.5мг/мл-2мл	тарилгын уусмал	амп	1	3		20
<b>Гурав. Эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл</b>							
1	Шприц 20.0 мл		хайрцаг	1	1	1	5
2	Шприц 10.0 мл		хайрцаг	1	2	1	10
3	Шприц 5.0 мл		хайрцаг	1	2	1	10
4	Шприц 3.0 мл		хайрцаг	2	3	1	15
5	Шингэн сэлбэх систем		ш	50	75	5	100
6	Уян зүү	№ 18.20.22.24	ш	15	20	2	50
7	Нэг удаагийн ариун зүү	№20.21.23	хайрцаг	1	1	1	3
8	Үзлэгийн бээлий 1 удаагийн	М Л хэмжээтэй	хайрцаг	1	2	2	5
9	Ариун бээлий	№7. №7.5	хайрцаг	1	2	2	10
10	Хөвөн 50гр	ш	ш	5	10	2	20
11	Бинт 7*14	ариун	ш	20	30	5	50
12	Хамрын гуурс	Хүүхэд, том хүний, нярай	ш	10	30		50
13	Шээсний катетр, уутны хамт	№ 12.14.16	ш	10	10		20
14	Ходоодны хаймсур		ш	5	5		20
15	Мөгөөрсөн хоолойн гуурс /№6/ №7.№7.5		ш		5		20
16	Цэвэрлэх бургуй		ш	3	5		20
17	Термометр зайнлас хэмждэг	ш	ш	5	10		20
18	<b>Бусад</b>						
19	Хүйтэн болон бүлээн жин	хурэлцэхүйц	ш	2	2		2
20	Шингэн бүлээсгэгч	хурэлцэхүйц	ш	1	2		3
21	Даралтны аппарат	механик	ш	2	2		2
22	Чагнуур		ш	2	2		2
23	Дуслын штатив		ш	2	3		3
24	Зориулалтын тэргэнцэр		ш	1	1		2

**Дөрөв. Халдвартгүйтгэл, ариутгалын бодис, хог хаягдал**

1	Жавелион №300		банк	4	10	2	20
2	Сод	15-25гр	уут	5	10	2	20
3	Тамедин 2.5%-300		фл	5	10	2	20
2	спирт денатурат 70%	0	литр	5	10	1	30
4	спирт чисть 96%		литр	2	3	1	20
5	Гар халдвартгүйжүүлэх ССБ	ДЭМБ-аас зөвлөсөн найрлагатай	литр	2	5	2	20
6	Халдвартгүйтэл хийх хувин, сав	резинэн гутал, нүдний шил, чагнуур г.м зүйлсийг дурж ариутгах боломжтой	ширхэг	5	7	5	7
7	Хог хаягдлын хувин	Ширхэг	ширхэг	3	3	3	3
8	Аюулгүй хайрцаг		ширхэг	2	2	2	5
9	Хог хаягдлын уут	Өнгө бүрээс тус бүр 1	боодол	2	2	2	3
10	Гарын саван 250гр	бактерийн эсрэг	ш	3	5	5	10
11	Эдийн саван		Ширхэг	2	2	2	3
12	Угаалгын нунтаг 300гр		Ширхэг	1	1	1	2
13	Жижиг автомакс	Ширхэг	1	1	1	1	3
14	Тарилгад хэрэглэгдэх иж бүрдлүүд тариур, хөвөнгийн сав, пенцевт, чанглуур, ивүүр, туншил хөрөөдөгч, наалдуулагч лент, бөөр хэлбэрийн таваг, аюулгүйн хайрцаг	ком	ш	1	1	1	3

**Тав. Сорьц цуглуулах биксэнд байх хэрэгслүүд**

1	Үзлэгийн бээлий 1 удаагийн		хос	5	10	3	20
2	нэг удаагийн зүү		ш	10	10	5	10
3	цэрний дээжний сав		ш	2	3	2	5
4	ваакум тэннерийн хуруу шил		ш	5	5	5	10
5	цаасан лент		ш	2	5	2	5
6	спирттэй хөвөн		уут	2	2	2	3
7	чанглуур		ш	2	2	2	3

**Зургаа.Тусгаарлах өрөөний эд хогшил,бичиг хэрэг**

1	Угаалтуур		ш	1	1	1	1
2	Өвчтний ор		ш	1	1	1	2
3	Үзэлгийн ор		ш	1	1	1	1
4	Ширээ		ш	1	1	1	1
5	Сандал		ш	1	1	1	2-3
6	Шүүгээ /эмийн/		ш	1	1	1	1
7	Жижиг шүүгээ		ш	1	1	1	1
8	Дотуур холбоо		ш	1	1	1	1

9	Ус буцалгагч		ш	1	1	1	1	1
10	Хөргөгч		ш	1	1	1	1	1
11	Аяга халбага		ш	1	1	1	1	1
12	Үзэг		ш	1	1	1	1	1
13	Бичгийг цаас		ш	20	20	20	20	20
14	ОО цаас		ш	2	2	2	2	2
15	Цагаан хэрэглэл		ш	1	1	1	1	1
16	Том толь		ш	1	1	1	1	1
17	Холбогдох эмнэлгийн маягтууд		ш	1	1	1	1	1
18	Бээлий /ахуйн зориулалтын зузаан/		хос	10	10	10	10	20

**Долоо.Тусгаарлах өрөөнд ашиглагдах багаж тоног төхөөрөмж**

1	Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч аппарат		ш	1	2-3	5	1	
2	Амьсгалын аппарат		ш		1	3		
3	Соруулгын аппарат		ш	1	1	1	1	
4	Хяналтын монитор		ш	1	1	1	1	
5	Дефибриллятор		ш	1	1	5	2.-3	
6	Шүүгээ /эмийн/		ш	1	1	1	1	
7	Дуслын болон тарилгын шахуурга		ш	1	1	5	1	
8	Баллонтой хүчилтөрөгч бобровтой		ш		1	1	5	1
9	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат		ш		1	1	5	1
10	Кварц		ш	1	1	5	1	
11	Зөөврийн цахилгаан үүсгүүр		ш	1	1	1	1	

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн  
A/09 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД АЖИЛЛАХ ЭМНЭЛ ЗҮЙН  
БАГИЙН ТОМИЛГОО, АЖИЛЛАХ ЖУРАМ**

1. Аймгийн эмнэл зүйн багийн эмч нар нь Эрүүл мэндийн яамны томилсон эмнэл зүйн багийн эмч, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын зөвлөх эмч Д.Давааноровоос зөвлөгөө зөвлөмж авч ажиллана.
2. Сум, сум дундын эмч нар аймгийн эмнэл зүйн багаас зөвлөгөө авна, аймгийн эмнэл зүйн баг шийдвэрлэх боломжгүй асуудал гарвал Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэл зүйн зөвлөх багаас зөвлөгөө авна.
3. Багт томилогдсон бүх хүмүүс шинэ коронавирусийн халдвартын үед ажиллах заавар, журмыг нарийн мөрдөж ажиллах ба сургалтад тасралтгүй хамрагдана.
4. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр утсаа унтраах, авахгүй байх, чөлөө авахыг хориглоно. Багаар ажиллах ажиллагаанд явах боломжгүй, хүндэтгэх шалтгаантай бол заавал урьдчилан Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Отгонбайгалд мэдэгдэж, шийдвэр гаргасны дараа чөлөөлөгдж болно.
5. Мэргэжлийн баг алсын дуудлагад эмэгтэйчүүд болон хүүхдийн нарийн мэргэжлийн эмч шаардлагагүй гэж үзвэл явахгүй байж болно.

**Нэгдүгээр баг**

1.1	Ц.Отгонбаяр	БОЭТ-ийн сүрьеэз, халдвартын эмч	89992119
2.1	Д.Чимгээ	БОЭТ-ийн дотрын зөвлөх эмч	88094965
3.1	Д.Батцэцэг	БОЭТ-ийн эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн эмч	99055387
4.1	Д.Отгонжаргал	БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч	86064686
5.1	С.Насантогтох	БОЭТ-ийн хүүхдийн эмч	86660074
6.1	Б.Ууганжавхаа	ЗЭСТ-ийн тархвар судлагч	89889757
7.1	Б.Гантөмөр	БОЭТ-ийн жолооч	88537316

**Хоёрдугаар баг**

8.1	Б.Отгончулуун	БОЭТ-ийн дотрын тасгийн эрхлэгч	88087866
9.1	Ш.Нэргүймаа	БОЭТ-ийн эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн зөвлөх эмч	99034993
10.1	Б.Мөнхбат	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч	88539435
11.1	Ц.Мөнхцэцэг	БОЭТ-ийн хүүхдийн эмч	88407289
12.1	Б.Нандинболор	ЭМГ-ын мэргэжилтэн, халдвартын эмч	89151380
13.1	У.Үүрийнтуяа	ЭМГ-ын мэргэжилтэн, эрүүл ахуйч	88690465
14.1	Х.Баттөр	ЭМГ-ын жолооч	88127266

**Гуравдугаар баг**

15.1	Н.Отгонбилэг	БОЭТ-ийн дотрын эмч	88127733
16.1	Д.Энх-Амгалан	БОЭТ-ийн Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн тасгийн эрхлэгч	89999890
17.1	Т.Пүрэврагчаа	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	80039493
18.1	Т.Оюундүү	БОЭТ-ийн хүүхдийн зөвлөх эмч	99100285
19.1	Л.Ренчинмядаг	БОЭТ-ийн тархвар судлагч	99928182
20.1	П.Мөнхбаатар	ЗЭСТ-ийн жолооч	89889757



## Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн A/09 дүгээр тушаалтын дөрөвдүгээр хавсралт

Коронавируст халдвартай (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх бүдүүвч

**Өвчтөн томуу, томуу тест өвчин (ТТӨ) эсвэл амьсгалын замын цочмог халдвартай байна уу?**  
Сүүлийн 14 хоногийн дотор халуурах, ханиалгах, холой өвдөх зэрэг амьсгалын замын цочмог халдвартын шинж тэмдэг илрэсэн үү? (Халуун нь 38 хэм ба түүнээс дээш)

